



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 59

Номгон

“Хуримтлалтай Хонгорчууд”
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хуримтлалтай Хонгорчууд” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг идэвхтэй оролцож дэмжин ажиллахыг уриалсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190391

D:/2020/Alban bichig/TH togtool-2020

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын
31-ний өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралт



**“ХУРИМТЛАЛТАЙ ХОНГОРЧУУД”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий үндэслэл


Өнөөдөр бид үндэсний хуримтлалын тухай анхаарлаа хандуулах шаардлагатай боллоо. Монгол Улсад үндэсний хуримтлал гэж зүйл маш бага. Улс үндэстний хуримтлал гэдэг хүн бүрийн хуримтлалын нийлбэр. Энэ тоо бага байхаар эдийн засаг байнга хямралд өртдөг. Нөгөө талд баян хоосны ялгаа асар гүнзгийрч байна. Банкны секторт байгаа хадгаламжийг аваад үзэхээр төвлөрөл их. Гэтэл нөгөө талд иргэд 600, 700 мянга, сая төгрөгний цалинтай ч хуримтлал үүсгэхгүй байгааг бид харж байна. Цалингийн дансаар нь цалин орсон ч хуримтлал үүсдэггүй. Хуримтлал үүсэхгүй байгаа шалтгааныг судлаж үзвэл “Би мөнгөтэй болохоороо хуримтлалтай болно” гэдэг буруу ойлголттой байдаг. Орчин үед баруунд нийгмийн сэтгэл зүй гэж том ойлголт бий болсон. Нийгмийн сэтгэл зүйг зөв удирдаж жолоодно гэдэг нь тухайн улсын үүрэг хариуцлага байдаг.

Хадгаламж гэдэг бол мөнгөтэй хүний зүйл. Мөнгөтэй хүн мөнгөө хадгаламжид хийдэг. Харин мөнгөгүй хүн хуримтлалыг бий болгодог. Монголчууд “Би мөнгөгүй юм чинь хадгаламж надад хэрэггүй. Энэ миний сонирхох зүйл биш” гээд хаячихдаг. Гэтэл хуримтлал гэдэг зуршил юм. Хүн мөнгө хуримтлуулах зөв дадалтай, зөв зуршилтай байвал хуримтлал бий болдог. Хуримтлал хадгаламж болж хувирдаг.


Монгол Улс эдүгээ 820 мянга гаруй айл өрхтэй, бараг хүн бүр банкинд данстай буюу 2018 оны байдлаар МУ-ын нэг иргэнд 1.1 хадгаламжийн данс ноогдож байгаа боловч нийт айл өрхийн 90 хувь нь хадгаламжгүй байгааг тогтоосон байна. МУ-ын нийт хадгаламж 2019 оны 1-р сарын байдлаар Монгол Улсын нийт хадгаламж 13 их наяд 139 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнийг 80 гаруй хувь нь иргэдийн хадгаламж байгаа юм. Дунджаар 1 иргэн 3.5 сая төгрөгийн хуримтлалтай байх тооцоолол байгаа боловч хадгаламж эзэмшигчдийг аваад үзэхэд нийт хадгаламжийн дүнгийн 60 хувийг нийт хадгаламж эзэмшигчдийн 1% нь л эзэмшиж, хадгаламж эзэмшигчдийн үлдсэн 99 хувь нь нийт хадгаламжийн 40 хувийг эзэмшиж байгаа юм.

Хэрэв иргэдийн ядаж гуравны нэг нь өрхийн орлогоосоо сар бүр 50 мянган төгрөг хуримтлуулж зуршвал арван жилийн дараа 13 сая төгрөгтэй болж, Монгол Улсын үндэсний хуримтлал 39.3 их наяд төгрөгөөр нэмэгдэх тооцоолол байна. Үндэсний хуримтлал нэмэгдэх нь улс орныг эдийн засгийг дархлаатай болгох юм. Энэ нь өрх гэрийн хувьд ч мөн ялгаагүй зүйл юм.

Баянхонгор аймгийн нийт хадгаламж 2019 оны байдлаар 115.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх онынхоос 8.9%-аар өсчээ.



Эх сурвалж: Монгол банкны Баянхонгор дахь салбар



Эх сурвалж: Монгол банкны Баянхонгор дахь салбар

Эндээс харахад Баянхонгор аймгийн нэг өрхийн хадгаламж 4.7 сая төгрөг, нэг хүнд ноогдох хадгаламж 1.3 сая төгрөг байгаа боловч улсын хэмжээгээр харагдаж байгаа нийт хадгаламж эзэмшигчдийн 1% нь нийт хадгаламжийн 60 орчим хувийг эзэмшиж байгаа юм. Нийт хадгаламж эзэмшигчдийн 99% нь нийт хадгаламжийн үлдсэн 40%-ийг эзэмшиж, нэг хүнд 1.1 хадгаламжийн данс оногдож байгааг харахад хадгаламж чухал гэдгийг хүр бүр мэдэж, хадгалахыг хүсч байна.

ЯАГААД ИРГЭН БҮР ХУРИМТЛУУЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА ВЭ?

1. Хүн амын орлогын түвшин харилцан адилгүй, ялгаа нь тэлсээр байгаа явдал. Хүн амын гуравны нэг нь эдүгээ ядуугийн ангилалд буюу сарын орлого нь амьдралын наад захын хоол, хүнсний хэрэгцээгээ хангаж чадахгүй байна.

2. Өнөөдрийн ЭЗ-ийн хүнд нөхцөлд энэ тоо өсөх хандлагатай байна. Дундаж анги буюу сарын хэрэгцээгээ хангаад тодорхой хэсгийг нь хуримтлуулах түвшний орлоготой иргэдийн тоо хүн амын хагасыг бүрдүүлж байна.

3. Монголчууд бидний дунд мөнгөө хуримтлуулах зуршил сайн тогтохгүй байна. Олон зуун жил мал аж ахуй эрхэлж ирсэн нүүдэлчдийн сэтгэлд хөрөнгийг мөнгөөр биш, малаар үржүүлэх бодол давамгайлсаар байгаа. Мөнгөө хуримтлуулах шалтгаан биш хуримтлуулахгүй байх шалтаг илүү их гаргаж тоочиж байна.

Эндээс дүгнэвэл:

1. Хүмүүс хуримтлалд бус хэрэглээнд орлогоо зарцуулж байна. Иргэдийн хэрэглээ өндөр байна. Аймгийн банкуудын захирлуудын ярьж байгаагаар нийт зээлийн 70-80 хувь нь зөвхөн өрхийн хэрэглээнд зориулагдаж байна. Энэ нь иргэд өрхийн санхүүгийн тооцоолол, сахилга бат байхгүйг харуулж байна.

2. Хоол хүнс, хувцас, гар утас, машин техник гэх мэт бүхий л бараа бүтээгдэхүүнээ гадны зах зээлээс худалдан авдаг нь илүү өртөг шингэсэн үнээр худалдан авч байгаа нь орлогоосоо давсан зардал гаргаж, хуримтлал үүсгэх боломжийг хязгаарлаж байна.

3. Шинэ жил, цагаан сар, наадам, хүүхдийн баяр, эмэгтэйчүүдийн баяр, цэргийн баяр гэх мэт маш олон баяр тэмдэглэж эргэж үр ашиг өгөхгүй зүйлд маш их зардлыг гаргаж байна.

4. Зарцуулаад үлдвэл хадгална гэсэн буруу бодолтой байдаг.

5. Дадал хэвшил болгоогүй. Хуримтлал чухал гэдгийг бүгд ойлгодог ч дадал хэвшилээ өөрчилж чаддаггүй.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Дэд хөтөлбөр хэрэгжих 4 жилийн хугацаанд Баянхонгор аймагт “Хуримтлалтай Хонгорчууд” банк бус санхүүгийн байгууллага байгуулах гэсэн алсын харааг дэвшүүлж ажиллана.

2.2 Дэд хөтөлбөрийн зорилго: Иргэн айл өрх бүр хуримтлалтай болж эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалан аймаг орон нутгийн эдийн засаг өссөн байна.

2.3 Нэгдүгээр дэд зорилт: Иргэдийн ахуйн зориулалттай зээл буурч, хадгаламж өссөн байна.

2.4 Хоёрдугаар дэд зорилт: Орон нутаг зохион байгуулалтад орж, гишүүдийн мэдлэг, хандлага сайжирсан байна.

Гурав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1 Дэд хөтөлбөр 2020-2024 оны хооронд 4 жилийн хугацаанд хэрэгжинэ. Энэ хугацаанд Дэлхийн Зөн Монгол ОУБ Баянхонгор-2 Хөгжлийн хөтөлбөр хэрэгждэг Баянхонгор, Баянлиг, Баянговь, Баянцагаан, Бууцагаан, Бөмбөгөр, Богд, Жинст гэсэн 7 сумаас бусад 13 сумд хэрэгжинэ. Жил бүр хэрэгжүүлэх сумдыг хүн амын тоо, газар зүйн байршил, хуримтлалын хэмжээг харгалзан 4 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1 Баянхонгор сумд 2020-2021 онд иргэдийг зохион байгуулж, шинэ бүлгүүдийг үүсгэнэ. Мөн урьд онуудад Эрдэнэцогт, Өлзийт, Галуут, Баянхонгор сумдад үүссэн бүлгүүдийг сургаж, бэхжүүлэх, хяналт тавих ажлыг хийнэ.

3.1.2 Шинэжинст, Баацагаан, Баян-Өндөр, Баянхонгор сумдад 2020-2022 онд иргэдийг зохион байгуулалтанд оруулж, шинэ бүлгүүдийг үүсгэнэ. Урьд онуудад үүссэн бүлгүүдийг сургах, бэхжүүлэх, хяналт тавих ажлыг хийнэ.

3.1.3 Баянбулаг, Гурванбулаг, Хүрээмарал, Баянхонгор сумдад 2022-2023 онд иргэдийг зохион байгуулалтанд оруулж, шинэ бүлгүүдийг үүсгэнэ. Урьд онуудад үүссэн бүлгүүдийг сургах, бэхжүүлэх, хяналт тавих ажлыг хийнэ.

3.1.4 Баян-Овоо, Заг, Жаргалант, Шаргалжуут тосгонд 2023-2024 онд иргэдийг зохион байгуулалтанд оруулж, шинэ бүлгүүдийг үүсгэнэ. Урьд онуудад үүссэн бүлгүүдийг сургах, бэхжүүлэх, хяналт тавих ажлыг хийнэ.

3.2 Дэд хөтөлбөрийг боловсруулах ажлыг хэсгийн уулзалтыг хийж, хөтөлбөрийг боловсруулж дуусгана.

3.3 Дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан байна.

3.4 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэрэгжих сум тус бүрт дараах ажлуудыг хийж хэрэгжүүлнэ. Үүнд:

3.4.1 Аймгийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.

3.4.2 Санхүүжилт орж ирсэний дараа хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх Дундын хадгаламжийн бүлэг аргачлалын орон нутгийн сургагч багш нарыг тодорхой шалгуурын дагуу сонгож, сургагч багшаар бэлтгэнэ.

3.4.3 Зорилтот газруудад “Хуримтлал, түүний ач холбогдол”, “ДХБ /Дундын Хадгаламжийн Бүлэг/ аргачлал гэж юу бэ?” Сургалтуудыг зохион байгуулж, иргэдийг сайн дураар нь нэгтгэж, бүлэг болгож зохион байгуулна.

3.4.4 Үүссэн бүлгүүдэд мөнгө хадгалах, хайрцаг болон бусад хэрэглэгдэхүүнийг олгоно.

3.4.5 Нэг бүлэг 15-25 гишүүнтэй байх ба нэг жилийн хугацаанд 8 модуль сургалтыг явуулж, чиглүүлэг өгнө.

3.4.6 Бүлгүүдэд жилд 1-2 удаа хяналт тавьж, үйл ажиллагааг нь сайжруулна.

3.4.7 Бүлгүүдийн удирдлагын багт жилд нэг удаа чадваржуулах сургалт зохион байгуулна.

3.4.8 Үйл ажиллагаа нь тогтмолжсон бүлгүүдийн дунд эргэн дүгнэх уулзалтыг зохион байгуулна.

3.4.9 Бүлэг зохион байгуулагдсан сумдын дунд “Хуримтлалтай хонгорчууд” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнана.

3.4.10 Бүлгүүдэд айлчлалаар очих үед “Эерэг хандлага”, “Бүлгийн хамтын ажиллагаа”, “Орлого зарлагаа бүртгэх нь”, “Сайн аав ээж байх”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтын хөтөлбөрүүдийг явуулж, иргэдийн мэдлэг хандлагыг сайжруулна.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт,
санхүүжилт, хугацаа, хяналт шинжилгээ үнэлгээ

4.1 Хуримтлалтай хонгорчууд дэд хөтөлбөр нь аймгийн хэмжээний хөтөлбөр бөгөөд Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 6.6-т заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Монгол Банкны Баянхонгор дахь салбар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

4.2 Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

4.3 Хөтөлбөрийг “Хонгорын Зөн” ТББ гэрээ байгуулан гүйцэтгэнэ.

4.4 Хонгорын Зөн ТББ нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, явцын болон жилийн эцсийн тайланг нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.5 Хонгорын Зөн ТББ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Хяналт шинжилгээ үнэлгээг дараах 4 арга замаар хийнэ. Үүнд:

4.5.1 Төслийг хэрэгжүүлэх явцад 3 төрлийн тайланг дараах байдлаар авч нэгтгэж, бүлгийн үйл ажиллагаанд сар бүр, улирал, жилээр хяналт тавьж ажиллана.

4.5.2 Сар бүрийн тайлан мэдээ /хүснэгтэн мэдээлэл/

4.5.3 Хагас жил, бүтэн жилээр бүлгийн ерөнхий тайлан мэдээ

4.5.4 Бүлгийн гишүүдийн өөрчлөлтийн түүх гэсэн байдлаар тайлан мэдээг нэгтгэдэг.

4.5.5 **Төслийн чиглүүлэгч нарын бүлгээр айлчлах айлчлал:** Төслийн чиглүүлэгч нар 1 бүлэгт жилд 8 удаа айлчилж, бүлгийн хурлыг чиглүүлэх, хяналт тавьж, сургалтын модулийг заана.

4.5.6 **Чадваржуулах сургалт:** Жилд 2 удаа орон нутгийн сургагч нарыг чадваржуулах сургалтанд хамруулна.

4.5.7 **Бүлгийн үнэлгээ:** ОН-ын сургагч нарын чиглүүлсэн бүлгийг жилд 1 удаа хөндлөнгийн хяналт хийнэ.

БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	ЭХЛЭХ/ ДУУСАХ ОГНОО	НИЙТ	ТӨСВИЙН ЖИЛ 1	ТӨСВИЙН ЖИЛ 2	ТӨСВИЙН ЖИЛ 3	ТӨСВИЙН ЖИЛ 4
Зорилго: Иргэн, айл өрх бүр хуримтлалтай болж эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, мөнгөн урсгалыг дотоодоо хадгалан, аймаг орон нутгийн эдийн засаг өссөн байна.	2020-2024 ОН	175 864 080	26 864 080	43 000 000	50 000 000	56 000 000
ЗОРИЛТ 1 Иргэдийн хадгаламж өсч, ахуйн зориулалттай зээл буурсан байна.		94 093 786	17 864 080	23 029 706	28 000 000	25 200 000
ЗОРИЛТ 2 Орон нутаг зохион байгуулалтанд орж, гишүүдийн мэдлэг хандлага дээшилсэн байна.		81 320 504	9 000 000	19 970 294	22 000 000	30 800 000
Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ		175 864 080	26 864 080	43 000 000	50 000 000	56 000 000
САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР						
Орон нутгийн төсөв		175 864 080	26 864 080	43 000 000	50 000 000	56 000 000

4.5.8 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төслийн загвар нь 12 сарын хугацаанд хэрэгжиж, үр дүнг тайлагнадаг тул санхүүжилтийг жил бүрийн 1-р улиралд багтаан олгох нь хөтөлбөрийг дэмжиж байгаа нэг хэлбэр юм.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

5.1 Хөтөлбөр хэрэгжснээр дараах үр дүн гарна. Үүнд:

5.1.1 ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН САХИЛГА БАТАД СУРГАХ, ХУРИМТЛАЛ ХИЙХ ДАДАЛ ХЭВШИЛТЭЙ БОЛГОДОГ: Иргэдийг санхүүгийн сахилга батат сургах, хуримтлал хийх дадал зуршилтай болгодог. Бага багаар тогтмолоор хуримтлал хийх, орлого зарлагаа тооцох, хэрэгцээгээгүй зардлаа хянах, хязгаарлах, шаардлагатай бичил зээлийг хүндрэл, чирэгдэлгүйгээр шийдэх, хүүхдүүд болон гэр бүлтэйгээ хуримтлуулах гэсэн нэг зорилго дор нэгдэж чаддаг нь энэхүү аргачлалын нэг давуу тал нь юм.

5.1.2 ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛД ЭЕРЭГЭЭР НӨЛӨӨЛДӨГ: Хүн ам нягтарших тусам соёлждог, хөгждөг гэж үздэг. Тэгвэл нүүдэлчин соёлтой манай орны хувьд хувь хүний соёл, хөгжлийг олон зуун жилийн суурин иргэншилтэй орны иргэдтэй харьцуулашгүй. Хувь хүний соёл, хөгжлийн наад захын ЦАГ БАРИХ, БУСДЫГ ХҮНДЭТГЭХ, САНАЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХАД ОРОЛЦОХ, ЗОРИЛГОТОЙ БАЙХ, ТӨЛӨВЛӨХ зэрэг хувь хүний чухал чадваруудыг өнөөгийн даяарчлалдсан нийгэм биднээс зайлшгүй шаардаж байна. Энэхүү аргачлал нь олон удаагийн хурал, дүрэм журам зэрэг онлог байдлаараа дамжуулан бүлэгт нэгдсэн иргэдэд дээрх чадваруудыг суулгаж байдаг бас нэг давуу тал юм.

5.1.3 ИРГЭДИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАНД ОРУУЛАХ, ХАМТЫН ХӨДӨЛМӨРИЙГ ДЭМЖДЭГ: Иргэдийг зохион байгуулалтанд оруулсанаар хамтрах, хамтарч хөдөлмөр эрхлэх суурийг тавьж өгдөг. Зөвхөн хуримтлал хийхээс гадна өөрсдийн нийгмийн санг бүрдүүлж, бий болсон сангаараа бүлгийн гишүүдийнхээ нийгмийн асуудал санаа тавихаас гадна нийгэмрүү хандсан сайн санааны ажлуудыг сайн дурын үндсэн дээр хийж хэрэгжүүлдэг нь тухайн орон нутагт төдийгүй, нийгэмд сайн үлгэр дуурайлал болж чаддаг.

5.2 Хөтөлбөр хэрэгжснээр дараах үр нөлөө гарна.

5.2.1 Аймгийн хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ.

5.2.3 Иргэд хэрэгцээгүй зардлаа хэмнэж, санхүүгийн сахилга батад сургалцаж, хуримтлал хийх дадал хэвшилтэй болно.

5.2.4 Иргэд бүлгийн зохион байгуулалтанд орж, хамтарч сурна.

5.2.5 Орон нутаг идэвхижнэ.

5.2.6 Бичил санхүүгийн үйлчилгээнд ахиц дэвшил гарна.

5.2.7 Орон нутгийн иргэд хүчирхэг, өөртөө итгэлтэй болж, нийгмийн капитал/чадваржсан хүний нөөц бий болно

_____оо_____